

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА П.БАТБААТАР ТАНАА

ИЛТГЭХ ХУУДАС

Шилэн дансны тухай хуулийн
2022 оны I улирлын хэрэгжилтийн тухай

2022.04.13

Улаанбаатар хот

Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт, хэрэгжилтийн байдал, тухайн хуулийн хэрэгжилтийг хангах талаар Дотоод хэргийн их сургуулиас авч хэрэгжүүлсэн ажлыг нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

**Нэг. Мэдээлэл байршуулж байгаа байгууллагын
статистик үзүүлэлт:**

Шилэн дансны тухай хуулийн 3.1-д заасны дагуу 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 1 байгууллагын шилэн дансны мэдээлэл хариуцсан 2 албан тушаалтнаас нэгдсэн системд 13 төрлийн мэдээллийг байршуулж, олон нийтэд тайлагнасан байна.

**Хоёр. Төсвийн шууд захирагчийн шилэн дансны
тухай хуулийн хэрэгжилтийн байдал:**

Мэдээлэл байршуулсан давтамжийг хугацаагаар тооцож үзэхэд 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 13 төрлийн мэдээг давтамжтайгаар 36 удаа, нийт мэдээллийг 100 хувь мэдээлсэн ба тайлант хугацаанд байршуулаагүй мэдээлэл байхгүй, 3 мэдээллийг ("2 дугаар сарын Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт", "хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл", "Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" мэдээллийн хэсэгт) хугацаа хоцроон байршуулсан байна.

Шилэн дансанд мэдээлэл байршуулсан хугацааны хэрэгжилтийн байдлыг дүгнэж үзвэл дундаж үзүүлэлтээр **91.7** хувьтай байна.

Гурав. Байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт:

Дотоод хэргийн их сургуулиас Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсөв гүйцэтгэлийн 9, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 6 төрлийн мэдээллийг жил, хагас жил, сар бүр, тухай бүр гэсэн хугацааны давтамжтайгаар байршуулж байна.

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар Дотоод хэргийн их сургуулийн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

1. Мэдээллийг төрөл, байршуулсан хугацаагаар нь ангилсан байдал:

№	Байршуулах мэдээллийн төрөл	Байршуулах мэдээ	Мэдээлсэн	Хугацаандаа	Хоцорсон	Байршуулаагүй мэдээлэл
1	2	3	4	5	6	7

1.Төсөв гүйцэтгэл						
1	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	-	-	-	-	-
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	4	4	3	1	-
3	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	3	3	3	-	-
4	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	-	-	-	-	-
5	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	-	-	-	-	-
6	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	3	3	3	-	-
7	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)	-	-	-	-	-
8	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр)	-	-	-	-	-
9	Санхүүгийн тайлан (Хагас жилээр)	-	-	-	-	-
10	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)	1	1	1	-	-
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт						
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)	1	1	1	-	-
2	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)	3	1	-	1	-
3	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)	3	3	3	-	-
4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр)	3	3	3	-	-
5	Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жил)	-	-	-	-	-
3. Бусад						
1	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр)	3	3	3	-	-
2	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр)	3	3	3	-	-
3	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр)	-	-	-	-	-

4	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр)	3	3	3	-	-
5	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр)	3	3	2	1	-
6	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр)	3	3	3	-	-
	НИЙТ ДҮН	36	36	33	3	-

Дөрөв. Цахим хуудасны мэдээлэл байршуулалтад хяналт тавьсан байдал:

Их сургуулийн захирлын 2022 оны 01 дүгээр албан даалгаварт “Шилэн дансны тухай хууль” түүнийг дагаж мөрдөх журмыг хэрэгжүүлж, санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд цахим хуудас, шилэн дансны нэгдсэн хуудсанд байршуулж, санхүүгийн мэдээллийн самбарт тогтмол мэдээлэлж хэвших талаар тусган хэрэгжилтэд хяналт тавьж, үүрэг чиглэлийг тухай бүр Санхүү төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж ажилласан.

Тав. Дүгнэлт:

Дотоод хэргийн их сургууль нь 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 36 мэдээллийг бүрэн байршуулсан.

Шилэн дансанд мэдээлэл байршуулсан хугацааны хэрэгжилтийн дүнг нэгтгэж үзвэл дундаж үзүүлэлтээр **91.7** хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллүүдийг олон нийтэд 100 хувь мэдээлэгдсэн нь төсвийн ил тод байдал хангагдаж, иргэдээс төсвийн хэрэгжилтэд хяналт тавих нөхцөлийг бий болгосон байх тул уг хуулийн үндсэн зорилтын хэрэгжилт “**ХАНГАЛТТАЙ**” түвшинд байна гэж дүгнэв.

Цаашид мэдээллийг холбогдох журмаар тогтоосон хугацаанд байршуулж мэдээлэх тал дээр анхаарах шаардлагатай байна.

ТАНИЛЦСАН:

ЗАХИРАЛ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



П.БАТБААТАР


САНХҮҮ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ, ХУРАНДАА

Ч.ЛХАГВАЖАВ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Д.ЭНХБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТӨВИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН АХМАД



Т.ОТГОНБААТАР